

АГУУЛГА

I ОРШИЛ	3
II ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	4
II.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
II.1.1 Ашигт малтмалын геологийн нөөц.....	5
II.1.2 Олборлолт болон баяжуулах хэсгийн хүчин чадал	5
II.1.3 Бүтээгдэхүүн гаргалт.....	5
II.1.4 Эдийн засгийн үзүүлэлт	5
II.1.5 Ил уурхайн үндсэн хэмжээсүүд	5
II.1.6 Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц	7
II.1.7 Ашиглалтын үеийн хаягдал, бохирдол:	8
II.1.8 Үйлдвэрлэлийн нөөц	9
II.2 Олборлолт.....	10
II.2.1 Уурхайн жилийн хүчин чадал	10
II.2.2 Уурхайн ажлын горим.....	10
II.2.3 Уулын ажлын төлөвлөлт	10
II.2.4 Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд ба технологийн процессууд.....	11
II.3 Баяжуулах хэсэг.....	12
II.3.1 Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо	13
II.3.2 Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмж	13
II.4 Уурхайн хүний нөөц, дэд бүтэц.....	14
III БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
III.1 Байгаль хамгаалах төлөвлөгөө.....	19
III.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
III.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
III.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
III.4 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
III.5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
III.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
III.7 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө	24
III.8 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	24
III.9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	25
III.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
III.11 БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	26
III.12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	28
IV ДҮГНЭЛТ	29
V АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	30

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 4. Тусгай зөвшөөрлийн талбайн сансрын байр зүйн зураг	4
Зураг № 9. Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын нээлтийн зураг-1	6
Зураг № 10. Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын нээлтийн зураг-2	6
Зураг № 11. Ил уурхайн хүрээгээр хаягдаж байгаа нөөц.....	7
Зураг №12. Ил уурхайн 1 дэх жилийн уулын ажлын төлөвлөлтийн зураг	10
Зураг №15. Ил уурхайн хөндлөн зүсэлт	11
Зураг №16. Гар ялгалт явуулах тоног төхөөрөмжийг холбох схем	13
Зураг № 17. Ажилчдын сууц	14
Зураг № 18. Ажилчдын амрах байр	15
Зураг № 19. Угаалгын хэсэг	15

Зураг №20. Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын гадаад тээврийн замын зураг	16
Зураг № 21. Цахилгааны үүсгүүрийн зураг.....	17
Зураг № 67. ОХШХ-ийн мониторингийн цэгүүд.....	22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 12. Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
Хүснэгт № 13. Тусгай зөвшөөрлийн талбайн солбилцолууд.....	4
Хүснэгт № 14. Ил уурхайн зохиомжлолд тусгасан үзүүлэлтийн хэмжээс	7
Хүснэгт № 15. Ашиглалтын нөөцийн хэмжээ.....	8
Хүснэгт № 16. Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо	9
Хүснэгт №19. Ашиглалтын жилүүдийн календарчилсан төлөвлөгөө	10
Хүснэгт №20. Ил уурхайн процесс	11
Хүснэгт №22. Уурхайн дотоод тээврийн зай	11
Хүснэгт №23. Тоног төхөөрөмжийн жагсаалт	12
Хүснэгт №26. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо.....	13
Хүснэгт №27. Тоног төхөөрөмжийн нэгдсэн хүснэгт	14
Хүснэгт №28. Төслийн нийт ажилчдын тоо.....	14
Хүснэгт № 29. Гадаад тээврийн замын рейс тооцоо	16
Хүснэгт № 30. Төслийн цахилгааны хэрэглээ.....	17
Хүснэгт №31. Төслийн нийт цэвэр усны хэрэглээ	17
Хүснэгт №129.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт № 131. ОХШХ-ийн мониторингийн цэгүүдийн координат.....	22
Хүснэгт №132.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	22
Хүснэгт №133.Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	23
Хүснэгт №134.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө	24
Хүснэгт №135.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	24
Хүснэгт №136.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	25
Хүснэгт №137.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	26
Хүснэгт №138.БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	27
Хүснэгт №139.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг	28

I ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Геохөгжил майнинг” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Ухаа овоогийн хайлуур жоншны ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

БОМТ боловсруулах аргачлал:

Тус төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.


Ухаа овоогийн хайлуур жоншны ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах төслийн БОМТ-нд 2025 онд нийт 16,198,500 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

II ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

II.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт № 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр	Ухаа овоо нэртэй хайлуур жоншны ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах
Ашигт малтмалын төрөл	Хайлуур жонш
Төслийн байршил	Дундговь аймгийн Адаацаг сум
Төслийн хугацаа	Ордыг 2 жил (бүрэн хүчин чадлаар бол) ашиглах ба хаалт, нөхөн сэргээлтийн хугацааг нэмж тооцсон дүнгээр 4 жил байна.
Төсөл хэрэгжүүлэгч	Геохөгжил майнинг ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011364130
Регистрийн дугаар	5648629
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Peace tower 1608 тоот
Тусгай зөвшөөрөл	124.2 га талбай бүхий ашигт малтмалын MV-017352 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын 72 тоот шийдвэрээр шилжүүлэн авсан



Зураг № 1. Тусгай зөвшөөрлийн талбайн сансрын байр зүйн зураг

Хүснэгт № 2. Тусгай зөвшөөрлийн талбайн солбилцолууд

№	Өргөрөг			Уртраг		
	град	мин	сек	град	мин	сек
1	46	35	02.52	106	0	01.27
2	46	34	31.69	106	0	01.27
3	46	34	31.71	105	59	11.17
4	46	34	13.00	105	59	11.17
5	46	34	13.00	105	59	01.20
6	46	34	49.11	105	59	01.20
7	46	35	02.52	105	59	23.22

II.1.1 АШИГТ МАЛТМАЛЫН ГЕОЛОГИЙН НӨӨЦ

Ордын 4-р хүдрийн биетэд 2008-2009 онд “Гео-Эрин” ХХК-ийн геологичид эрэл үнэлгээ, хайгуулын ажлыг явуулж, улмаар 2011 оны 01 дүгээр сарын 07–ны өдөр нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг УУЯ, АМГ-ын дэргэдэх ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн бодитой В зэрэглэлийн 49.97%-ийн агуулгатай 32.5 мян.тн хүдэр, боломжтой С зэрэглэлийн 49.64%-ийн агуулгатай 15.9 мян.тн хүдэр, нийт бодитой ба боломжтой (В+С) зэрэглэлээр 49.86%-ийн агуулгатай 48.4 мян.тн хүдрийн нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн байна.

II.1.2 ОЛБОРЛОЛТ БОЛОН БАЯЖУУЛАХ ХЭСГИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Уурхайн жил бүрийн олборлолт харилцан адилгүй байх бөгөөд 1 дэх жил 10.65 мян.тн, 2 дахь жил 24.54 мян.тн хүдэр олборлон, баяжуулна.

II.1.3 БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТ

Уурхайгаас олборлосон 44.28%-ийн дундаж агуулга бүхий 35.19 мян.тн хүдрийг буталж, шигшин бэлтгэсний дараа гар аргаар ялган ФК-85, ФК-75 маркийн баяжмалыг гаргана. Бүтээгдэхүүн гаргалтын хувьд ФК-85 маркийн баяжмалын хэмжээ 9,110.91 тн, ФК-75 маркийн баяжмалын хэмжээ 4,550.71 тн, бага агуулгатай буюу 32.59%-ийн агуулгатай хүдэр 8,614.71 тн-ыг гаргана.

II.1.4 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Орд ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 22,275.79 тн баяжмал болон бага агуулгатай хүдэр борлуулна. Борлуулах бүтээгдэхүүний хувьд ФК-85 маркийн баяжмалыг 950.0 мян.төг, ФК-75 маркийн баяжмалыг 850.0 мян.төг, бага агуулгатай хайлуур жоншийг агуулга тутамд 4,000 төгрөгөөр борлуулна.


Орд ашиглалтын хугацаанд нийт 13.65 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 11.41 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 2.00 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Ашиглалтын хугацаанд нийт 2.76 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болно. 10 хувийн хорогдуулалтын норм тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ 1,209.07 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 30% байна, хөрөнгө оруулалтаа 1.5 жилд нөхнө.

II.1.5 ИЛ УУРХАЙН ҮНДСЭН ХЭМЖЭЭСҮҮД


Ашиглалтын систем: Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордыг ил аргаар, автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.

Уурхайн нээлт: Ордын нээлтийг XIII-7-7 буюу 4-В-8 блокийн баруун хойд захаас 105°59'27.14"E, 46°35'2.50"N координатаар дотоод ерөнхий траншейгаар +1,521 м түвшнээс +1,511 м түвшин хүртэл 10 м гүнтэй 800/00 налуутай, 10.0 м өргөнтэй траншейгаар нэвтэрнэ. Ил уурхайн нээлт нь 80 м урттай, 40 м өргөнтэй байна.

Ордын уул-техникийн нөхцөл нь ашигт малтмалыг аюулгүй, эдийн засгийн хувьд ашигтай байхаар уурхайн нээлтийг хийнэ. Хүдрийн биет нь газрын гадаргад ил гарштай ба хойд хэсэг буюу өндөрлөг тал нь хүдрийн биетийн хамгийн их зузаан хэсэг юм.



Зураг № 2. Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын нээлтийн зураг-1



Зураг № 3. Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын нээлтийн зураг-2

Ил уурхайн талбай: Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын уурхайн ашиглалтын хугацаанд 1 ил уурхай үүснэ. Ил уурхай нь 340 м-ийн урттай 1.3 га талбайг хамарсан байна.

Ил уурхайн гүн: Бодитой В зэрэглэлийн нөөцийн хамгийн их гүн 35 м, дунджаар 25 м гүн ба ил уурхайн загварчлалын хамгийн их гүн нь 30 м, дунджаар 20 м гүнтэй ил уурхай

үүснэ. Ил уурхайн ёроолоос доош орших 5 м-ийн гүнтэй нөөцийг уурхайн эцсийн жилд 5 м-ийн гүнтэй малталт хийж нөөцийг бүрэн олборлоно. Ингэснээр хөрс хуулалт багатай болж, нөөцийг бүрэн олборлох нөхцөл үүсэж байна.

Ил уурхайн хажуугийн өнцөг: Ордын агуулагч чулуулгийн бат бөхийн дундаж коэффициент нь $f=6$ бол, хүдрийн бат бөхийн дундаж коэффициент нь $f=8$ /Проф.Протодьяконовын ангиллаар/ байна. Энэ нь чулуулгийн бат бөхийн үзүүлэлтээр бөх ба бөхдүү зэрэгт хамаарч байна.

Доголын өндөр: Уурхайн жилийн хүчин чадал, ашиглагдах экскаваторын утгалтын гүнээс хамааруулж олборлолтын доголын өндөр $H_d=5$ м, хаалтын доголын өндрийг 10.0 м байна.

Доголын хажуугийн өнцөг: Чулуулгийн шинж чанарыг үндэслэн доголын хажуугийн өнцөг $\alpha_d=650$ байна. Ил уурхайн ерөнхий хажуугийн өнцөг $\alpha_d = 50^\circ$ градусаас хэтрэхгүй байна.


Ил уурхайн бусад хэмжээсүүд: Ил уурхайн ажлын талбайн хамгийн бага өргөн 37.5 м, аюулгүйн бермийн өргөн 3.0 м, траншейн налуу 80°_{00} байна.

Хүснэгт № 3. Ил уурхайн зохиомжлолд тусгасан үзүүлэлтийн хэмжээс

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээс
1.	Ил уурхайн хаалтын доголын өндөр	м	10
2.	Ил уурхайн олборлолтын доголын өндөр	м	5
3.	Доголын хажуугийн өнцөг	град	65
4.	Уурхай ерөнхий хажуугийн өнцөг	град	50
5.	Ажлын талбайн өргөн	м	37.5
6.	Траншейн өргөн	м	10.0
7.	Траншейн налуу	$^\circ_{00}$	80
8.	Доголын аюулгүйн берм-(тавцан)-ийн өргөн	м	3.0

II.1.6 Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц

Ил уурхайн хүрээ хязгаар хойд хэсгээрээ тусгай зөвшөөрлийн хилд тулсан учир бодитой В зэрэглэлийн нөөцөөс 0.18 мян.м³ буюу 0.49 мян.тн хүдэр ил уурхайн хүрээ хязгаараар хаягдаж байна.



Зураг № 4. Ил уурхайн хүрээгээр хаягдаж байгаа нөөц

Ил уурхайн хүрээнд бодитой В зэрэглэлээр 11.64 мян.м³ буюу 32.00 мян.тн, боломжтой С зэрэглэлээс 0.05 мян.м³ буюу 0.13 мян.тн хүдэр ил уурхайн хүрээгээр өртөж

олборлогдоно. Нийт ил уурхайн хүрээн дотор 11.68 мян.м³ буюу 32.13 мян.тн хүдэр, 163.86 мян.м³ хөрс орж байна.

Хүснэгт № 4. Ашиглалтын нөөцийн хэмжээ

№	Блокийн дугаар	Ашиглалтын блокийн талбай, мян.м ²	Хөрсний эзлэхүүн, мян.м ³	Ашигт малтмал	
				Нөөц, мян.м ³	Нөөц, мян.тн
1	В-1	0.35	19.46	0.15	0.42
2	В-2	1.25	19.46	0.90	2.49
3	В-3	1.80	19.46	1.42	3.89
4	В-4	2.36	19.46	2.29	6.29
5	В-5	2.16	19.46	1.69	4.64
6	В-6	1.81	19.46	1.60	4.40
7	В-7	2.09	19.46	2.34	6.43
8	В-8	1.41	19.46	1.25	3.45
Бодитой В нөөц		13.24	155.65	11.64	32.00

II.1.7 АШИГЛАЛТЫН ҮЕИЙН ХАЯГДАЛ, БОХИРДОЛ:

Ашиглалтын үеийн нийт хаягдлын хэмжээ 0.37 мян.м³ буюу 1.02 мян.тн бөгөөд нөөцийн 3.19%-тай тэнцэж байна. Ашиглалтын үеийн нийт бохирдлын хэмжээ 1.48 мян.м³ буюу 4.08 мян.тн бөгөөд нөөцийн 12.75%-тай тэнцэж байна.

II.1.8 Үйлдвэрлэлийн нөөц

Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын бодитой В зэрэглэлийн нөөцөд тулгуурлаж боломжтой С зэрэглэлийн нөөцийг ил уурхайн хүрээ хязгаарт өртүүлэн олборлох бөгөөд хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу бодитой (В) болон боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг магадалсан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадалсан В' үйлдвэрлэлийн нөөц нь 35.19 мян.тн хүдэр болж байна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 12.83 м³/м³ болж байна.

Хүснэгт № 5. Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Геологийн нөөц									Ил уурхайн хүрээний гадна үлдэх нөөц						Ашиглалтын нөөц						Ашиглалтын үеийн хаягдал				Ашиглалтын үеийн бохирдол				Бортоор нэмэгдэх нөөц	Үйлдвэрлэлийн нөөц					
№	Блокийн дугаар	Блокийн талбай	Ашигт малтмалын дундаж зузаан	Ашигт малтмалын эзлэхүүн	Эзлэхүүн жин	Ашигт малтмалын нөөц	Дундаж агуулга	Хайлуур жоншны нөөц	Ашигт малтмалын дундаж зузаан	Ашигт малтмалын эзлэхүүн	Эзлэхүүн жин	Ашигт малтмалын нөөц	Дундаж агуулга	Хайлуур жоншны нөөц	Ашигт малтмалын дундаж зузаан	Ашигт малтмалын эзлэхүүн	Эзлэхүүн жин	Ашигт малтмалын нөөц	Дундаж агуулга	Хайлуур жоншны нөөц	Хаягдал	Хаягдал нөөц		Бохирдол	Бохирдуулагч чулуулаг		Блокийн дугаар	Хөрсний эзлэхүүн		Ашигт малтмалын нөөц		Дундаж агуулга	Хайлуур жоншны нөөц		
Хэм.нэгж	мян.м²	м	мян.м³	тн/м³	мян.тн	%	мян.тн	м	мян.м³	тн/м³	мян.тн	%	мян.тн	м	мян.м³	тн/м³	мян.тн	%	мян.тн	%	мян.м³	мян.тн	%	мян.м³	мян.тн	мян.м³		мян.м³	мян.м³	мян.тн	%	мян.тн			
1	В-1	0.28	0.55	0.15	2.75	0.42	53.56	0.22						0.55	0.15	2.75	0.42	53.56	0.22	3.19%	0.00	0.01	12.75%	0.02	0.05		В'-1	19.46	0.17	0.46	47.33	0.22			
2	В-2	0.90	1.00	0.90	2.75	2.49	52.38	1.30						1.00	0.90	2.75	2.49	52.38	1.30	3.19%	0.03	0.08	12.75%	0.12	0.32		В'-2	19.49	0.99	2.73	46.28	1.26			
3	В-3	1.21	1.17	1.42	2.75	3.89	51.96	2.02						1.17	1.42	2.75	3.89	51.96	2.02	3.19%	0.05	0.12	12.75%	0.18	0.50		В'-3	19.50	1.55	4.26	45.91	1.96			
4	В-4	1.55	1.48	2.29	2.75	6.29	51.47	3.24						1.48	2.29	2.75	6.29	51.47	3.24	3.19%	0.07	0.20	12.75%	0.29	0.80		В'-4	19.53	2.51	6.89	45.48	3.14			
5	В-5	1.43	1.18	1.69	2.75	4.64	45.45	2.11						1.18	1.69	2.75	4.64	45.45	2.11	3.19%	0.05	0.15	12.75%	0.21	0.59		В'-5	19.51	1.85	5.08	40.16	2.04			
6	В-6	1.21	1.32	1.60	2.75	4.40	51.11	2.25						1.32	1.60	2.75	4.40	51.11	2.25	3.19%	0.05	0.14	12.75%	0.20	0.56		В'-6	19.51	1.75	4.82	45.16	2.18			
7	В-7	1.44	1.62	2.34	2.75	6.43	55.03	3.54						1.62	2.34	2.75	6.43	55.03	3.54	3.19%	0.07	0.20	12.75%	0.30	0.82		В'-7	19.53	2.56	7.04	48.63	3.42			
8	В-8	0.94	1.52	1.43	2.75	3.94	39.48	1.56	1.52	0.18	2.75	0.49	39.48	0.20	1.52	1.25	2.75	3.45	39.48	1.36	3.19%	0.04	0.11	12.75%	0.16	0.44		В'-8	19.50	1.37	3.78	34.89	1.32		
Бодитой В нөөц		8.96	1.23	11.82	2.75	32.50	50.06	16.24	1.52	0.18	2.75	0.49	39.48	0.20	1.23	11.64	2.75	32.00	50.06	16.04	3.19%	0.37	1.02	12.75%	1.48	4.08			156.02	12.75	35.06	44.29	15.53		
7	С-1	0.07	0.55	0.04	2.75	0.11	53.56	0.06	0.55	0.04	2.75	0.11	53.56	0.06														В'-9							
8	С-2	0.35	1.00	0.35	2.75	0.95	52.38	0.50	1.00	0.35	2.75	0.95	52.38	0.50														В'-10							
9	С-3	0.59	1.17	0.69	2.75	1.89	51.96	0.98	1.17	0.69	2.75	1.89	51.96	0.98														В'-11							
10	С-4	0.82	1.48	1.21	2.75	3.32	51.47	1.71	1.48	1.21	2.75	3.32	51.47	1.71														В'-12							
11	С-5	0.73	1.18	0.86	2.75	2.36	45.45	1.07	1.18	0.86	2.75	2.36	45.45	1.07														В'-13							
12	С-6	0.60	1.32	0.80	2.75	2.19	51.11	1.12	1.32	0.80	2.75	2.19	51.11	1.12														В'-14							
13	С-7	0.65	1.62	1.05	2.75	2.90	55.03	1.60	1.62	1.05	2.75	2.90	55.03	1.60														В'-15							
14	С-8	0.47	1.52	0.72	2.75	1.97	39.43	0.78	1.52	0.72	2.75	1.97	39.43	0.78														В'-16							
15	С-9	0.16	0.56	0.09	2.75	0.24	39.48	0.09	0.56	0.04	2.75	0.11	39.48	0.04												0.05	В'-17	8.21	0.05	0.13	39.48	0.05			
Боломжтой С нөөц		4.43	1.16	5.80	2.75	15.94	48.87	7.91	1.16	5.75	2.75	15.81	49.72	7.85												0.05		8.21	0.05	0.13	39.48	0.05			
Нийт В+С нөөц		13.39	1.19	17.61	2.75	48.43	49.86	24.15	1.34	5.93	2.75	16.30	49.41	8.05	1.23	11.64	2.75	32.00	50.06	16.04	3.19%	0.37	1.02	12.75%	1.48	4.08	0.05	Нийт В'	164.23	12.80	35.19	44.28	15.58		

II.2 ОЛБОРЛОЛТ

II.2.1 УУРХАЙН ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын ил уурхайн жилийн хүчин чадал 25.0 мян.тн хүдэр байна. Уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтын ажлыг 1, 2 дахь жилд өөр өөр байна. Эхний жил бичиг баримтын бүрдлээс шалтгаалан бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй гэж үзэн 11.0 мян.тн байх бөгөөд 2 дахь жилд бүрэн хүчин чадлаар ажиллана. Ил уурхайн олборлолтыг төлөвлөсөн хүчин чадлаар 2 жилийн хугацаанд олборлохоор байна.

II.2.2 УУРХАЙН АЖЛЫН ГОРИМ

Уурхайн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан Ухаа-Овоогийн хайлуур жоншны орд нь эхний жилд 57 хоног ажиллахаар байна. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.


II.2.3 УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын ил уурхайн ахилт гүнзгийрэлтээс хамаараад жил бүрийн хөрс хуулалт, хүдэр олборлолт харилцан адилгүй байна.


Хүснэгт №6. Ашиглалтын жилүүдийн календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жилүүд	Хөрс хуулалт		Жонш олборлолт				Уулын цул	Хөрс хуулалтын дундаж коэффициент	
	Хөрс	Шимт хөрс	В зэрэглэлээр	С зэрэглэлээр	В+С зэрэглэлээр				
Хэмжих нэгж	мян.м3	мян.м3	мян.м3	мян.м3	мян.м3	мян.тн	мян.м3	м3/м3	м3/тн
1 дэх жил	48.47	0.80	3.82	0.05	3.87	10.65	53.14	12.72	4.63

Уурхайн 1 дэх жилийн уулын ажлын төлөвлөлт: ХШ-7-7 буюу 4-В-8 блокийн баруун хойд захаас нээлтийг хийж, уулын ажлын өрнөлийг хүдрийн биетийн дагуу явуулна. 1 дэх жилд 3.87 мян.м³ буюу 10.65 мян.тн хүдэр олборлож, 48.47 мян.м³ хөрс болон 0.80 мян.м³ шимт хөрс хуулна. Ил уурхай +1,521 м түвшнээс +1501 м түвшин хүртэл 20 м гүнтэй болж 1.3 га талбайг хамарсан байна.



Зураг №5. Ил уурхайн 1 дэх жилийн уулын ажлын төлөвлөлтийн зураг



Зураг №6. Ил уурхайн хөндлөн зүсэлт

II.2.4 Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд ба технологийн процессууд

Хүснэгт №7. Ил уурхайн процесс

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын систем	1. Хөрс хуулалт	1.1. Шимт хөрс хуулах 1.2. Шимт хөрс ачих 1.3. Шимт хөрс тээвэрлэх 1.4. Өрөмдлөг тэсэлгээ 1.5. Хөрс ухаж ачих 1.6. Хөрс тээвэрлэх 1.7. Гадаад овоолгод хураах 1.8. Овоолго түрэх
	2. Хүдэр олборлолт	2.1. Өрөмдлөг тэсэлгээ 2.2. Хүдэр ухаж ачих 2.3. Тээвэрлэх 2.4. Баяжуулах хэсгийн түр овоолгод буулгах

Шимт хөрс хуулах: Шимт хөрсийг HYUNDAI R520LC маркийн экскаватороор хуулж автосамосвалоор тээвэрлэн шимт хөрсний овоолгод хураана. Ил уурхайн эхний жилд 5.57 мян.м³, 2 дахь жилд 13.0 мян.м³ буюу нийт 2 жилийн хугацаанд 18.57 мян.м³ шимт хөрс хуулж овоолно.

Үүнээс 2.66 мян.м³ шимт хөрс ил уурхайгаас гарах бол үлдэгдэл нь зам талбай, овоолгын суурь, баяжуулах хэсгийн суурь, барилга байгууламжийн суурийн хэсгээс гарах болно.

Хөрс, хүдрийн ухаж ачих процесс: Ордын хэмжээнд хөрс, хүдрийг HYUNDAI-R520LC маркийн 3.2 м³-ийн утгуурын багтаамжтай экскаватороор ухаж ачна. Нийт ажлын хэмжээ 161.57 мян.м³ хөрс, 16.88 мян.м³ шимт хөрс, 12.80 мян.м³ хүдэр байна.

Уурхайн дотоод тээвэр: Ил уурхайгаас хуулах хөрс, шимт хөрс болон олборлох хүдрийг FAW CA3250-P66K2L1T1 маркийн 25 тн даацтай автосамосвалаар тээвэрлэж хөрсийг овоолго хүртэл, хүдрийг баяжуулах хэсгийн түр овоолго хүртэл тээвэрлэнэ. Уурхайн гүнзгийрэлт болон овоолгын ахилтаас хамаарч дотоод тээврийн автосамосвалуудын тээврийн зай харилцан адилгүй байна. Дараах хүснэгтэд автосамосвалуудын тээврийн зайг харуулав.

Хүснэгт №8. Уурхайн дотоод тээврийн зай

Ашиглалтын сар	Хүдэр тээвэрлэх дундаж зай, м	Хөрс тээвэрлэх дундаж зай, м
----------------	-------------------------------	------------------------------

1 дэх жил	600	700
2 дахь жил	650	800
Дундаж	625	750

Овоолго: Хөрс болон шимт хөрсний овоолгийг хэвгийжүүлэх, хаягдлын овоолго, бүтээгдэхүүн гадаад тээвэрт ачих зэрэгт LIUGONG-LG953 маркийн 3.0 м³ утгуурын багтаамжтай утгуурт ачигч ашиглана. Овоолгын процесс нь автосамосвалоор хөрсийг буулгаж үлдэц асгацыг утгуурт ачигчаар түрэн захлах хэлбэрээр овоолго байгуулна

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд:

“Геохөгжил майнинг” ХХК нь Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордод дараах үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төсөлд тусгасан байна.

Хүснэгт №9. Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Гүйцэтгэх ажил	Марк	Загвар	Тоо, ширхэг /тооцооны/
1	Өрөмдлөг	AtlasCopco ROC L-6	Өрмийн машин	1 /оператор компани/
2	Хөрс, шимт хөрс хуулалт	HYUNDAI R520LC	Экскаватор	1 /өөрийн/
3	Хүдэр олборлолт			
4	Шимт хөрс, хөрс болон хүдэр, хаягдал тээвэр	FAW-CA3250	Автосамосвал	2 /өөрийн/
5	Шимт хөрс, хөрс бүтээгдэхүүн, хаягдлын овоолго	SDLG-LG953	Утгуурт ачигч	1 /өөрийн/
Нийт		-		5

II.3 БАЯЖУУЛАХ ХЭСЭГ


Уурхай нь төслийн хүчин чадлаараа ажиллах үед жилд 44.28% CaF₂-ын дундаж агуулга бүхий 25.0 мян.тн хүдэр олборлох ба уг хүдрийг гар аргаар ялгалт хийнэ. Гар ялгалт хийхдээ бутлуур, шигшүүр, туузан конвейер зэрэг төхөөрөмжийг ашиглана.

Уурхайн баяжуулах хэсэг нь жил бүр 2 ээлжээр, 12 цагаар ажиллана. Баяжуулах хэсэг нь ордын зүүн талд Цооног-4-өөс 20 м-ийн зайд байрлана. Уурхай нь эхний жил бичиг баримтын бүрдлээс шалтгаалан 57 хоног ажиллана.

Хүдэрт хийгдсэн бодисын найрлагын судалгаа, агуулагч чулуулгийн судалгаа болон технологийн туршилтын үр дүнд үндэслэн тус ордын хүдрийг хоёр шатны бутлалт, нэг шатны шигшилт хийсний дараа бүхэллэг жоншийг гар аргаар ялгах нь оновчтой болохыг тогтоож цаашид тус ордын хүдрийг энэхүү схемээр баяжуулахыг санал болгосон. Туршилтын үр дүнгээр 28.2% болон 36.11%-ийн жоншны агуулгатай ядуу хүдэр гаргасан байсан ба тооцоонд тухайн 2 хүдрийг нэгтгэн нэг дундаж агуулгатай хүдэр болгон борлуулана

Уурхайгаас ирэх хүдрийн хамгийн том ширхэглэл -500 мм байх ба хүдрийг хоёр шатны бутлалт, нэг шатны шигшилт хийсний дараа гар ялгалт хийж ФК-85, ФК-75 маркийн баяжмал болон хаягдал хүдрийг ялган авна.

Анхдагч хүдрээс хайлуур жоншийг гар аргаар ялгах болсон нь хүдрийн шинж чанар, агуулагч чулуулаг болон хүдрийн найрлагын судалгаа шинжилгээний үр дүн, хайлуур жоншны бүхэллэг шинж зэргээс хамаарч байгаа болно.



Зураг №7. Гар ялгалт явуулах тоног төхөөрөмжийг холбох схем

II.3.1 БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТЫН ТООЦОО

Уурхайгаас олборлосон 44.28%-ийн дундаж агуулга бүхий 35.19 мян.тн хүдрийг буталж, шигшин бэлтгэсний дараа гар аргаар ялган ФК-85, ФК-75 маркийн баяжмалыг гаргана. Бүтээгдэхүүн гаргалтын хувьд ФК-85 маркийн баяжмалын хэмжээ 9,110.91 тн, ФК-75 маркийн баяжмалын хэмжээ 4,550.71 тн, бага агуулгатай буюу 32.59%-ийн агуулгатай хүдэр 8,614.71 тн-ыг гаргана.

Хүснэгт №10. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Үзүүлэлт		Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд		Нийт
			1 дэх жил	2 дахь жил	
Хүдэр	Хэмжээ	тн	10,647.72	24,543.11	35,190.83
	Агуулга	%	44.28	44.28	44.28
Баяжмал /ФК -85/	Гарц	%	25.89	25.89	25.89
	Агуулга	%	85.00	85.00	85.00
	Хэмжээ	тн	2,756.70	6,354.21	9,110.91
Баяжмал /ФК -75/	Гарц	%	12.93	12.93	12.93
	Агуулга	%	75.00	75.00	75.00
	Хэмжээ	тн	1,376.75	3,173.42	4,550.17
Бага агуулгатай хүдэр	Гарц	%	24.48	24.48	24.48
	Агуулга	%	32.59	32.59	32.59
	Хэмжээ	тн	2,606.56	6,008.15	8,614.71
Хаягдал	Гарц	%	36.70	36.70	36.70
	Агуулга	%	12.52	12.52	12.52
	Хэмжээ	тн	3,907.71	9,007.32	12,915.03

II.3.2 БАЯЖУУЛАХ ХЭСГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Ил уурхайгаас баяжуулах хэсэгт ирж байгаа хүдэр нь анхан шатны хацарт бутлуураар бутлагдана. Анхан шатны хацарт бутлуурт бутлагдсан хүдэр нь хоёрдугаар шатны хацарт бутлуурт өгөгдөнө. Хоёрдугаар шатны хацарт бутлуураас гарсан бүтээгдэхүүнийг чичиргээт шигшүүрээр шигшин -25 мм-ээс доош ширхэглэлтэй хэсгийг хаягдлын овоолгод овоолон, +25 мм-ээс дээш ширхэглэлтэй хэсгийг гар аргаар ялгана.

Баяжуулах хэсэгт ажиллах үндсэн тоног төхөөрөмжийг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

Хүснэгт №11. Тоног төхөөрөмжийн нэгдсэн хүснэгт

№	Төхөөрөмжийн нэр	Марк	Бүтээмж, тн/цаг	Ш/тоо	Хөдөлгүүрийн чадал, кВт
1	Бункер	-	20-40	1	-
2	Хацарт бутлуур-1	PE-600x900	20-70	1	55
3	Хацарт бутлуур-2	PE250*400	5-20	1	15
4	Шигшүүр	2YK1237	16-90	1	7.5
5	Туузан конвейер	Конвейер	-	4	3
6	Тоос баригч	YTXF-280	-	1	5

II.4 УУРХАЙН ХҮНИЙ НӨӨЦ, ДЭД БҮТЭЦ

Уурхайн удирдах албан тушаалтан буюу захирал, уурхайн дарга уулын инженер, ээлжийн мастер-ХАБЭА-н мэргэжилтэн, нярав, нягтлан зэрэг орон тооны ажилчдыг үндсэн ажилтнаар, бусад орон тооны ажилчдыг орон нутгаас гэрээт ажилтан байдлаар авч ажиллуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт №12. Төслийн нийт ажилчдын тоо

№	Хэсэг нэгж	Ажилчдын тоо, хүн
1	Уулын хэсэг	23
2	Баяжуулах хэсэг	16
3	Засвар үйлчилгээний хэсэг	4
4	Захиргаа аж ахуй, үйлчилгээний хэсэг	11
	Нийт	54


Ажилчдын сууц: Ажилчдын хотхонд нийт 35-40 хүний амьдрах орчинг шаардлагатай тавилга, эд хогшлоор тоноглогдсон байна. Ажилчдын сууцыг зөөврийн тохижуулсан сууцаар шийдэж хүн амьдрах тав тухыг бүрдүүлсэн байна. 1 зөөврийн сууцанд 6-8 хүн байрлана.



Зураг № 8. Ажилчдын сууц



Зураг № 9. Ажилчдын амрах байр



Зураг № 10. Угаалгын хэсэг

Хоолны газар: Цайны газар нь ажилчдын сууцны нэгэн адил тохижуулан хүн тав тухтай хооллох орчныг бүрдүүлсэн байна. Хоолны газарт 1 удаадаа 15-20 хүн зэрэг хооллох ба 2 ээлжээр хооллох бөгөөд 1 хүнд дунджаар 1.9 м² талбай ноогдож байна.

Холбооны байгууламж: Уурхайн орчимд үүрэн телефоны G-Mobile-н сүлжээ барьдаг. Уурхайн экскаватор, автосамосвал, утгуурт ачигч зэрэг үндсэн техник хэрэгслийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана.

Түлшний агуулах: Түлшний агуулахаас тоног төхөөрөмжүүдийг түлшээр хангана. Түлшний агуулах нь 50000 литр түлш хадгалах багтаамжтай байна. Эдгээр нь тусдаа шахуурга болон шүүлтүүртэй байна. Түлшийг шүүж цэвэрлэсний дараа техник хэрэгслүүдийг түлшээр цэнэглэнэ. Мөн түлш ачих, буулгах хэсэгт гал унтраах, аянга

зайлуулагч хэрэгслүүд байрлана. Түлш асгарч хөрсийг бохирдуулахаас сэргийлж автомашин цэнэглэх талбайг хатуу хучилттайгаар хийж өгнө.

Засвар механикийн барилга байгууламж: Уурхайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үйлдвэрийн талбайд байрлах засварын талбайд хийж гүйцэтгэнэ. Засварын талбайд дугуй засвар, гагнуур, компрессорын станц зэргийг эхний ээлжинд байгуулна.

ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

Гадаад тээвэр: “Геохөгжил майнинг” ХХК нь өндөр агуулгатай жоншийг Чойр өртөө хүртэл автотээврээр тээвэрлэн төмөр замаар Замын-Үүд боомтоор БНХАУ-руу гаргахаар төслийн ТЭЗҮ-д төлөвлөсөн байна.

Харин бага агуулгатай хүдрийг хүдэр баяжуулах үйлдвэрт тонн тутмыг 130.38 мян.төг буюу агуулга тутамд 4,000 төгрөгөөр тооцож борлуулахаар төлөвлөжээ.



Зураг №11. Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын гадаад тээврийн замын зураг

Хүснэгт № 13. Гадаад тээврийн замын рейс тооцоо


Бүтээгдэхүүн	Ашиглалтын жил	Жилд ажиллах хоног	Бүтээгдэхүүн гаралтын тооцоо	Автос амосв алын тн	Автос амосв алын рэйси удаа/жил	Хоногт зорчих гадаад тээврийн рейс
		хоног				Удаа
Жоншны баяжмал /ФК-85/	1 жилд	111	2,756.70	25	110	1
Жоншны баяжмал /ФК-75/	1 жилд	111	1,376.75	25	55	0.5
Бага агуулгатай хүдэр	1 жилд	111	2,606.56	25	104	1

Дулаан хангамж: Уурхайн барилга байгууламжийг сэрүүний улиралд цахилгаанаар халаахаар тооцсон бөгөөд тухайн халаалтын зардлыг цахилгааны зардалд оруулан тооцлоо.

Цахилгаан хангамж:

Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордын хувьд баяжуулах хэсгийн тоног төхөөрөмж, ажилчдын хотхон, уурхайн гэрэлтүүлэг гэсэн хэсгүүдэд цахилгааны хэрэгцээ үүсэж байгаа бөгөөд одоогийн байдлаар уурхайн хотхоны

баруун хойно байрлуулсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нарны панелаар цахилгаан хэрэглэгчдийг ханган ажиллаж байна. Мөн уурхайн хотхоны орчимд дизель генератор байрлуулсан бөгөөд шаардлагатай тохиолдолд уг генераторыг ашиглах юм.



Зураг № 12. Цахилгааны үүсгүүрийн зураг

Хүснэгт № 14. Төслийн цахилгааны хэрэглээ

№	Цахилгаан хэрэглэгч	Тооцооны чадал, кВт	Ажиллах хугацаа				Цахилгаан зарцуулалт, кВт.цаг	
			1 дэх жил		2 дахь жил		1 дэх жил	2 дахь жил
			Хоног	Цаг	Хоног	Цаг		
1	Баяжуулах хэсэг	83.96	111	20	223	20	186,388	374,456
2	Цайны газар	23.23	111	20	223	20	51,571	103,606
3	Засварын хэсэг	21.66	111	20	223	20	48,091	96,615
4	Бусад	20.60	111	20	223	20	45,732	91,876
5	Уурхайн гэрэлтүүлэг	9.98	111	20	223	20	22,145	44,489
Нийт		159.43					353,926	711,041

Усан хангамж, усны хэрэглээ: төсөлтэй холбоотой усны хэрэгцээг тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдөж гаргасан гүний худгаас хангана. Ордыг ашиглах үед усны дараах үндсэн хэрэглэгч байна. Үүнд:

- Унд ахуйн ус
- Зам талбайн усалгаа
- Ногоон байгууламжийн усалгаа

Ухаа-Овоогийн хайлуур жоншны ордыг ашиглахад шаардлагатай нийт усны хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №15. Төслийн нийт цэвэр усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Усны хэрэглээ (м3)				Шаардлагатай ундаргын хэмжээ, (л/сек)			
		Унд ахуй	Зам усалгаа	Нөхөн сэргээлтийн усалгаа	Нийт	Унд ахуй	Зам усалгаа	Нөхөн сэргээлтийн усалгаа	Нийт
1	1 дэх жил	466.20	1,040.00		1,506.20	0.05	0.30		0.31
2	2 дахь жил	936.60	1,160.00		2,096.60	0.05	0.34		0.35
3	3 дахь жил			14,528.94	14,528.94			4.20	4.20
Нийт		1402.80	2,200.00	14,528.94	18,131.74	0.05	0.34	4.20	4.20

Ордыг ашиглахад шаардлагатай усны ундаргын хэмжээ 4.2 л/с байна. Ашиглалтын хугацаанд нийт 18.13 мян.м³ ус хэрэглэхээр байна.

III БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм. “Геохөгжил майнинг” ХХК-ийн “Ухаа овоогийн хайлуур жоншны орд” -ыг ил аргаар ашиглах төсөл нь 3-4 жилийн хугацаанд хэрэгжинэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь хэрэгжиж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Геохөгжил майнинг” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачилалд зааснаар төслийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгахаар заасан тул “Ухаа овоогийн хайлуур жоншны орд”-ыг ашиглах төслийн нөхөн сэргээлтийн товч төлөвлөгөөг зардлын хамтаар тусгаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хийж гүйцэтгэлээ.

БОМТ-ий биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11-р сарын 01-ний дотор БОУАӨЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

III.1 БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

III.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт №16.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн үнэлгээ /мян.төг/	Зардал /мян.төг/ 2025	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэл нөлөөллийг бууруулах төлөвлөгөө							
1	Хайлуур жонш бутлах үед тоосжилт тархах	Бутлуурт тоос баригч суурилуулах	Бултуур		3,000	Эхний жилд	-Агаарын тухай хууль, -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль,
2	Зам дагуу хөрс эвдэрч, тоос тархах	Зам арчилгааны зардал	Дотоод тээврийн зам		Үйл ажиллагааны зардал	Тухай бүрт	
3	Хүнд машин механизмын нөлөөгөөр Nox, CO, Sox хийгээр агаар орчныг бохирдуулах	Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Техник, тоног төхөөрөмжүүд		650	Жил бүр	
Газрын гадаргуу хөрсөнд үзүүлэх нөлөөлөл							
4	Хөрс хуулалт, хөрсний овоолгоос газрын гадаргын хэлбэр төрх өөрчлөгдөх, эвдрэх	Ил уурхайн талбайн хэмжээнээс хэтэрч ажиллахгүй байх		-	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны туршид	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага” MNS5917:2008 “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага” MNS5916 :2008 Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд: MNS3298-91, Хөрс-агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох: MNS3310-918, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ: MNS5850-2019
5	Уул уурхайн үйл ажиллагаанаас өнгөн хөрс эвдрэх, доройтох	Өнгөн хөрсийг стандартын дагуу хуулах, овоолго хийх, арчлах		-	-		
6	Хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх	Үйлдвэрлэлийн технологийн замын зураг гаргаж зөвхөн заасан замаар машин техникүүдийг зорчуулах, Лицензийн талбай доторх замыг тэмдэгжүүлэх		-	500	Жил болгон /эвдэрсэн тохиолдолд засварлана/	
7	Машин техникийн засвар үйлчилгээ бусад үйл ажиллагаанаас хөрс бохирдуулах	Засвар үйлчилгээ хийхэд хөрсийг нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх хөрсийг хатуу хучилттай болгох	-	-	850	Үйл ажиллагаа эхлэхийн өмнө	

**Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших “Ухаа овоо нэртэй хайлуур эжоншны
ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны БОМТ**

8	Хөрс доройтох, цөлжих эсэх	Эвдрэлд орсон талбайд биологийн нөхөн сэргээлт хийх,	Уурхайн талбайд	-	БНС-н зардалд орсон.	Үйл ажиллагааны туршид	
9	Хөрсний бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөх	Уулын ажлыг зөвхөн уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Уурхайн талбайд	-	Үйл ажиллагааны зардал		
10	Зам дагуу хөрс эвдэрч, тоос тархах	Зам арчилгааны зардал	Уурхайн замд		500	Үйл ажиллагааны туршид	
Ургамлын төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл							
11	Ургамлын бүтэц бүрэлдэхүүнд нөлөөлөх эсэх	Эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийх,	Уурхайн талбайд үйл ажиллагаа дуусахад	-	БНС-н зардалд орсон	Үйл ажиллагааны туршид нэг удаа	-Ургамал хамгааллын тухай хууль, -Байгалийн ургамлын тухай хууль, -MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”
12	Ургамлын биомассд нөлөөлөх эсэх	Тоос үүсэх талбайг услах	Уурхайн зам	-	Үйл ажиллагааны зардал	Байнга	
13	Ургамлын тусгаг бүрхцэд нөлөөлөх эсэх	Олон салаа зам гаргахгүй байх, Гол замд тэмдэглэгээ хийх	Уурхайн талбайд		Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны туршид нэг удаа	
Усан орчинд үзүүлэх нөлөөлөл							
14	Гүний усны нөөцөд нөлөөлөх эсэх. Хөрсний усыг бохирдуулахгүй байх	Усны хэмнэлттэй ашиглах, усыг дахин ашиглах	Худгийг тоолууржуулах	-	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны туршид	Ус ашигласны төлбөр (2013 оны 327-р тогтоол); Усны тухай хууль; “Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982
Амьтны аймаг							
15	Амьтны гоц халдварт өвчин тархах	Зэрлэг амьтан агнахгүй байх, мэрэгчид ихсэхээс сэргийлж ажилчдын тосгонд ариутгал халдваргүйжлийн арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх	Тусгай зөвшөөрлийн талбай		Үйл ажиллагааны зардал	Тогтмол	"Амьтны аймгийн тухай" хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
Нийт зардал					5,500		

III.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн ТЭЗҮ болон БОННУ-д тусгасны дагуу ашиглалтын хугацаанд 3-4 дэх жилд нөхөн сэргээлтийн ажил хийгдэх тул 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тус төсөлд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөөгүй болно.

III.3 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус ордын ойр орчмын бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

III.4 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус ордын ойр орчмын бүсэд түүх соёлын дурсгалт газар байхгүй. Иймд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө болно.

III.5 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/642 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний хөлс, үнэ тариф”-ыг үндэслэн тооцов.


Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Дундговь аймгийн Адаацаг сумын нутаг дэвсгэрт “Ухаа овоогийн хайлуур жоншны орд” –ыг олборлохоор “Геохөгжил майнинг” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа болон үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөлөх байдлын үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан байх бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Геохөгжил майнинг” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 сарын 01-ний дотор холбогдох сум, аймаг, төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий

**Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших “Ухаа овоо нэртэй хайлуур жоншны
ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны БОМТ**

л үйл ажиллагааг “Геохөгжил майнинг” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

Хүснэгт № 17. ОХШХ-ийн мониторингийн цэгүүдийн координат



Зураг № 13. ОХШХ-ийн мониторингийн цэгүүд

№	Шинжилгээ авах төрөл	Мониторингийн цэг	
1	Агаарын сорьц шинжилгээ /PM2.5, PM10, TSP, дэгдэмхий органик нэгдэл/	105°59'11.73"	46°34'49.945"
2		105°59'41.56"	46°34'51.251"
3		105°59'59.076"	46°34'58.053"
4		105°59'29.761"	46°34'52.259"
5	Шуугианы түвшин тодорхойлох хэмжэлт	105°59'13.063"	46°34'46.676"
6	Хөрсний задлан шинжилгээ /агрохими, хүнд металл, эрүүл ахуй/	105°59'14.43"	46°34'44.21"
7		105°59'29.773"	46°34'52.049"
8		105°59'40.904"	46°34'51.297"
9		105°59'56.76"	46°34'59.778"
10	Мониторингийн хатуу цэг /хөрс/	105°59'53.5"	46°34'47.84"
11	Мониторингийн хатуу цэг /агаар/	105°59'53.433"	46°34'48.489"
12	Ургамлын мониторинг	105°59'53.6"	46°34'49.0"
13		105°59'14.7"	46°34'44.2"
14		105°59'31.452"	46°34'50.806"
15	Усны ерөнхий химийн шинжилгээ	105°59'13.76"	46°34'50.43"

Хүснэгт №18. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж, жил	2025 он	Баримтлах стандарт, арга, аргачлал
1. Агаарын чанар						
1.	(PM10, PM2.5, SO ₂ , NO ₂ , CO)	Ухаш, зам, хотхон, ялгах хэсэг	4	Улиралд 1 удаа	200	-MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.	Дуу шуугиан	бутлан ангилах хэсэг	1	1	30	
3	Дэгдэмхий органик нэгдэл	Үйлдвэр орчимд	1	1	50	

**Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших “Ухаа овоо нэртэй хайлуур жоншны
ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны БОМТ**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж, жил	2025 он	Баримтлах стандарт, арга, аргачлал
						- MNS 6063:2010 Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ
2. Хөрсний чанар						
1	Аргохими	Ухаш, овоолго, хотхон, зам	4	Улиралд 1 удаа	175.5	-MNS 3985: 87. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл -MNS 3310:91. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
2	Хүнд металл	овоолго, зам	2	Улиралд 1 удаа	42	
3	Эрүүл ахуй	хотхон	1	Улиралд 1 удаа	35	
3. Усны чанар						
1	Усны ерөнхий үзүүлэлтүүд, Микробиологийн шижилгээ	Ундны усны эх үүсвэрээс /гүний худаг/	1	Улиралд 1 удаа	46	- MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх
4. Мониторинг						
1	Ургамлын мониторингийн судалгаа	Нөлөөлөлд өртөж буй талбайн хэмжээнд	3	1	Үйл ажиллагааны зардал	
2	Амьтны мониторингийн судалгаа	Нөлөөлөлд өртөж буй талбайн хэмжээнд		1	Үйл ажиллагааны зардал	
НИЙТ					578.5	

III.6 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №19.Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Эхний жилд	Зардал /мян.төг/ 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх ёстой байдаг.	Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт булгийн эхийг хаших ажлыг хийж гүйцэтгэнэ.	3,500.0	Үйл ажиллагааны хүрээнд жилд 1 удаа хийнэ.	Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, журам, стандартын дагуу
Нийт			3,500.0		



III.7 ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн А/58 зарлигийн 2-т заасан тэрбум мод тарих төслийн хүрээнд нийт 2 жилийн хугацаанд 600 ш мод тарьж ургуулах, арчлах ажлыг хийхээр төлөвлөж зардлыг тооцоолсон. Тус ажлын үнэд модыг тарих, услах, арчлах, ургуулах гэх мэт шаардлагатай бүхий л зардлыг тооцсон дүнгээр тооцсон болно.

Тус төслийн БОННУ 2025 оны 10-р сарын 15-ны өдөр БОУАӨЯ-д батлагдсан бөгөөд тухайн жилийн тариалалт хийх хугацаа өнгөрсөн тул тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модыг дараа жилийн төлөвлөгөөнд улирааж тарих боломжтой.

Хүснэгт №20.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал /мян.төг/	Баримтлах стандарт ба аргачлал
1	“Геохөгжил майнинг” ХХК нь тэрбум мод тарьж ургуулах ажлын хүрээнд ОН-н Байгаль орчны газартай зөвшилцөж мод тарих газрыг сонгож ажиллана.	300 ш	МУ-ын Ерөнхийлөгчийн А/58 дугаар зарлиг
Төсөвт өртөг		750	

III.8 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

Хүснэгт №21.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/ 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
1	Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	-	Байнга	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхой-лолт, ерөнхий анги
2		Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	-	Үйл ажиллагааны туршид	
3		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайд	900	Жил бүр	

**Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших “Ухаа овоо нэртэй хайлуур жоншны
ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны БОМТ**

4		Уурхайн цогцолборын эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах	Далан байгуулах	-	Уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнө	
	Нийт			900		

III.9 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Геохөгжил майнинг” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай.

Хүснэгт №22.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/ 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
1	Хог хаягдлаас үүсэх орчны бохирдол	Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх	Уурхайн удирдлага	420	Үйл ажиллагааны туршид	Хог хаягдлын тухай хууль
2		Ахуйн хагуу хог хаягдал хаях сав байрлуулах	Уурхайн удирдлага	250	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
3		Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих	Уурхайн удирдлага	500	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
4		Аюултай хог хаягдлыг хадгалах хэсгийг барих, тэмдэглэгээ хийх, ачуулж зайлуулах	Уурхайн удирдлага	800	Уурхайн ажил эхлэхийн өмнө болон үйл ажиллагааны туршид	
	Нийт			1,970		

III.10 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа техник, технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

**Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших “Ухаа овоо нэртэй хайлуур жоншны
ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны БОМТ**

Хүснэгт №23. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал /мян.төг/ 2025 он	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Байнга	-MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -Шуугианы норм, аюулгүй ажиллагаа-ны ерөнхий шаардлага -MNS 12.4. 005 - 1985 Хөдөлмөр хамгаалал. –жил бүр Шуугианаас -хамгаалах хэрэгсэл ба аргууд
2	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
3	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
5	Газрын чанарын хянан баталгааг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгүүлэх	Хайлуур жоншны орд	3,000.0	5 жил тутамд	
6	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
Нийт			3,000.0		

III.11 БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч “Геохөгжил майнинг” ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч “Геохөгжил майнинг” ХХК нь Дундговь аймгийн Адаацаг сумын Өвөр-урт багийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

***Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших “Ухаа овоо нэртэй хайлуур жоншны
ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны БОМТ***

Хүснэгт №24.БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	Бомт хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	Дундговь аймгийн Адаацаг сумын Өвөр- урт багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	Дундговь аймгийн Адаацаг сумын Өвөр-урт баг
2	БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар		БОУАӨЯ-нд
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ- ий хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	Засаг даргын тамгын газар

III.12 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

Хүснэгт №25. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5,500,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (ТНС, БНС, хаалт)	-
3	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3,500,000
4	Тэрбум мод төслийн хүрээнд	750,000
5	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	900,000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,970,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	578,500
8	Тухайн жилийн удирдлага зохион байгуулалт	3,000,000
	Нийт	16,198,500

IV ДҮГНЭЛТ

Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт байрлах “Ухаа овоо нэртэй хайлуур жоншны ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээнүүдийг тухай бүрт хэрэгжүүлж тухайн онд хийсэн ажлаа холбогдох газруудаар хянуулж батлуулах шаардлагатай байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2025 онд нийт 16,198,500 сая.төг зарцуулахаар төлөвлөлөө.

“Геохөгжил майнинг” ХХК нь байгалийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж зэргийг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй.

Мөн олборлолтонд өртсөн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих дүрэм, журмын дагуу чанартай гүйцэтгэх шаардлагатай байна.

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний ажлуудыг холбогдох стандарт, арга аргачлалын дагуу тогтоосон хугацаанд чанд сахин биелүүлж байх хэрэгтэй.

Уурхайн үйл ажиллагааны үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сайтар чанд сахих, аюулын үед хэрэгжүүлэх дотоод төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай.

V АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Байгаль орчныг хамгаалах тухай” Монгол Улсын хууль, УБ 1995
2. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль~УБ 2012
3. Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулиудын эмхтгэл, УБ 1999
4. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
7. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
8. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
9. “Ухаа-овоогийн хайлуур жоншны ордын 4-р хүдрийн биетэд 2008-2009 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан”, УБ, 2011
10. “Ухаа-овоогийн хайлуур жоншны ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах ТЭЗҮ”, УБ, 2024.
11. “Ухаа-овоогийн хайлуур жоншны ордын 4-р хүдрийн биетийг ил аргаар ашиглах” төслийн БОННУ тайлан, УБ, 2025.
12. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014 он
13. <http://www.legalinfo.mn/>